



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар A/24

Сүхбаатар сум

Г

Г

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сэлэнгэ аймгийн Стратеги төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ө.Сувдаа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Болорзул

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Ёндонжамц

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга

Б.Энхбат

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

О.Мөнхбаяр


-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Лувсандагва	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
Б.Энхболд	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Б.Мөнхтөр	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Б.Саруултөгс	-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
З.Түвшинтөгс	-Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Ч.Жаргалсайхан	-Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Ж.Од	-Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Л.Зоригтбаатар	-Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
Д.Гүндэгмаа	-Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

2.Аймгийн стратеги төлөвлөгөөг улс, аймгийн хөгжлийн бодлогын зорилт, салбарын стратеги төлөвлөгөөг үндэслэн журам, аргачлалын дагуу боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Аймгийн стратеги төлөвлөгөөний төслийг 2021 оны 2 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ